



# ХасБанк ХК-ийн 2024 оны 1-р улирлын санхүүгийн үр дүн

<https://www.xacbank.mn/page/financial-operational-result>  
Apr 22, 2024



	<b>Хуудас #</b>
2024 оны 1-р улирлын санхүүгийн үр дүн	3-7
Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт	8-9
Хураангуй орлого үр дүнгийн тайлан, тэнцэл	10-11
Бусад ач холбогдол бүхий мэдээлэл	12-13

# Санхүүгийн үр дүн

2024 оны 1-р улирал

ROE\* Цэвэр ашиг  
**26.3%** **MNT 42.0 тб**

EPS ХАС  
**MNT 39.9** **MNT 710**

1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт **20.9%**  
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлт **38.3%**

## Орлогын тайлангийн гол үзүүлэлт:

- 2024 оны 1-р улирлын **цэвэр хүүгийн орлого MNT 73.3 тэрбум төгрөгт** хүрч, өмнөх улирлаас +0.4%-р өссөн байна;
- Хүүгийн бус орлого (шимтгэл, хураамж болон валют арилжааны орлого гэх мэт) 19.0 тэрбум төгрөг, хүүгийн бус зардал (үйл ажиллагааны зардал, хураамж шимтгэлийн зардал гэх мэт) 35.5 тэрбум төгрөгт хүрч тус тус 27.5%, 21.1% буурсан нь улирлын чанартай өөрчлөлт юм;
- 1-р улиралд активын чанар сайжирсан тул эрсдэлийн сангийн зардал тухайн тайлант хугацаанд нэмэгдээгүй бөгөөд ашигт ажиллагаанд эерэг нөлөө үзүүлсэн байна;

## Балансын үзүүлэлт:

- 2024 оны 1-р улиралд цэвэр зээлийн багц 5.9%-р өссөн бөгөөд тус өсөлтөд: жижиг дунд бизнесийн зээл (+5%), цалингийн зээл (+6%), моргейж (+14%), Хаслизинг (+7%) тус тус өссөн бол Корпорэйт зээлийн багц тогтвортой байна.
- Нийт хадгаламж тайлант улиралд +3.3% өсөж 2.246 тэрбум төгрөгт хүрсэн бол харилцах дансны үлдэгдэл 611 тэрбум төгрөгт хүрч өмнөх улирлаас 12.9% буурсан байна.

## Монголбанкны тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт:

- 2024 оны 1-р улирлын эцсийн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа (tier I) 20.95% (байвал зохих хэмжээ 12.5%), төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа (liquidity) 38.1% (байвал зохих хэмжээ 25%) тус тус байна.
- Зээлтэй адилтган тооцох активын төвлөрлийн харьцаа 300%-с ихгүй байх зохицуулалттай бөгөөд ХасБанкны хувьд тус харьцааг 33%-д удирдаж байгаа нь активын төвлөрөл бага байгааг илтгэж буй үзүүлэлт болно.


Note/Тайлбар:

\* ROE is calculated based on quarterly net profit after taxes divided by average equity for the period. ROE буюу “Өөрийн хөрөнгийн өгөөж”-ийг тооцохдоо тухай улирлын татварын дараах цэвэр ашгийг тухай улирлын дундаж өөрийн хөрөнгийн үлдэгдэлд харьцуулан тооцсон.

# Санхүүгийн үзүүлэлтийн тренд


2024 оны 1-р улирал

**Цэвэр ашиг**  
тэрбум төгрөг




**ROE\***


Дундаж өөрийн хөрөнгийн




**Ногдол ашиг**  
Тэрбум төгрөг



**Нийт актив**  
тэрбум төгрөг



**1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа**



**Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа**



Note/Тайлбар:

\* ROE is calculated based on quarterly net profit after taxes divided by average equity for the period. ROE буюу “Өөрийн хөрөнгийн өгөөж”-ийг тооцохдоо тухай улирлын татварын дараах цэвэр ашгийг тухай улирлын дундаж өөрийн хөрөнгийн үлдэгдэлд харьцуулан тооцсон.

\*\* 2023 оны 2-р хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах саналыг 2024 оны 4-р сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэхээр хүлээгдэж байгаа.

# Зээлийн үйл ажиллагаа

## 2024 оны 1-р улирал

Зээлийн багц

**2,911**

тэрбум төгрөг

Нийт зээлийн тоо


**169k**

Цахим зээлийн тоо

**100k**

### Нийт зээл

тэрбум төгрөг



### Сегментээр

тэрбум төгрөг



### Нэмэлт мэдээлэл:

- Q1-ийн зээлийн өсөлтийг жижиг дунд бизнесийн зээл, орон сууц худалдан авах зээл, хэрэглээний зээлүүд болон санхүүгийн түрээсийн багцаас түлхүү бүрдүүлсэн байна.
- Чанаргүй зээлийн хэмжээг нийт зээлийн 3%-с доош удирдан ажиллаж байгаа нь банкны системдээ хамгийн сайн үзүүлэлт юм. Зээлийн багцын хэт төвлөрлөөс зайлсхийх, компанийн засаглал болон эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа тусгал нь активын чанарт ийнхүү сайнаар нөлөөлж байдаг.

Тайлбар:

Зээлийн багц гэдэг нь зээлийн үндсэн өрийн үлдэгдэлийг ойлгоно.

Чанаргүй зээлийн харьцааг тооцоходоо нь чанаргүй зээлийг (90 ба түүнээс дээш хоног хугацаа хэтэрсэн зээл) нийт зээлийн багцад харьцуулсан тооцдог.

# Дотоод эх үүсвэр

2024 оны 1-р улирал

Нийт харилцах, хадгаламж

**2,858**

тэрбум төгрөг

Нийт дансны тоо


**1,296k**

Хадгаламжийн дансны тоо

**500k**

## Харилцах, хадгаламж

тэрбум төгрөг



## Бүтээгдэхүүн

тэрбум төгрөг



## Нэмэлт мэдээлэл:

- Эх үүсвэрийн бүтэц нь харилцах данс, хадгаламж болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрээс бүрддэг.
- Тайлант хугацаанд харилцах дансны үлдэгдэл 99 тэрбум төгрөгөөр буурсан бол хадгаламжийн үлдэгдэл 173 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Өмнөх оны жилийн эцсээр мөнгөний зах, нөөцийн удирдлагын зорилгоор хийгдсэн богино хугацаатай эх үүсвэр төлөгдсөнөөр 2024 оны 1-р улирлын эцсийн банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн үлдэгдэл буурсан.

Тайлбар:


# Гадаад эх үүсвэр

## 2024 оны 1-р улирал

ХасБанк нь харилцагчдадаа урт хугацаатай санхүүжилт олгох зорилгоор Олон Улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. 2023 онд нийт 205.5 сая ам.долларын эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн бол үүний 130 сая ам.доллар нь 2022 онд ОУСК болон FMO зэрэг байгууллагуудтай байгуулсан урт хугацаат эх үүсвэрийн гэрээний дагуу орж ирсэн бол үлдсэн 75.5 сая ам.доллар нь 2023 онд шинээр эхлүүлсэн хэлцлүүд болно. 2024 оны 1-р улирлын байдлаар шинээр аливаа гадаад эх үүсвэр татаагүй байгаа бөгөөд өмнө нь авсан эх үүсвэрээс гэрээний дагуу 4 сая ам.долларын төлөлт хийсэн.

### Гадаад эх үүсвэр

Сая ам.доллар



### Олон улсын түнш банк, санхүүгийн байгууллагууд



# Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан


1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт (Tier I)

**20.9%**

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлт (Liquidity)

**38.3%**

Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний нэмэлт шаардлага  
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод шаардлага



Давуулан биелүүлсэн нөөц өөрийн хөрөнгө нь аливаа болзошгүй эрсдэлийг давахаас гадна ирээдүйд активын тэлэлт хийх болон ногдол ашиг тараах боломжийг бий болгодог.

**34.5** Бэлэн мөнгө

**1046.9**  ТБҮЦ

**420.0**  Монголбанканд байршуулсан хөрөнгө

**97.8** "BBB-" ба түүнээс дээш үнэлгээтэй гадаадын СБ-д байршуулсан хөрөнгө

Түргэн борлогдох актив: 1599.3 тэрбум төгрөг



# Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан - үргэлжлэл

Тусгайлан өөрөөр заагаагүй бол хувиар (%) илэрхийлэв	2023 I улирал	2023 II улирал	2023 III улирал	2023 IV улирал	2024 I улирал
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) +/-15%	9.4%	4.4%	4.3%	-1.3%	-1.9%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар) +/-30%	14.5%	4.7%	4.8%	-1.4%	-2.9%
Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа <300%	39.2%	37.1%	23.6%	38.6%	33.0%
Үндсэн хөрөнгө нийт хөрөнгийн харьцаа <8%	1.6%	1.6%	1.6%	1.3%	1.4%
Хадгаламжийн төвлөрлийн харьцаа <25%	8.8%	7.0%	6.9%	7.8%	7.8%

Тусгайлан өөрөөр заагаагүй бол хувиар (%) илэрхийлэв	2023 I улирал	2023 II улирал	2023 III улирал	2023 IV улирал	2024 I улирал
Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй):					
Банкны хувьцаа эзэмшигчид	0.0%	0.0%	1.3%	0.8%	0.9%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.1%	0.1%	0.1%	0.1%	0.1%
Банкны бусад холбогдох этгээд	2.4%	3.6%	3.6%	3.2%	3.0%
Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй):					
Банкны хувьцаа эзэмшигчид	0.0%	0.0%	1.4%	0.9%	0.9%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.3%	0.3%	0.3%	0.3%	0.3%
Банкны бусад холбогдох этгээд	3.9%	5.9%	3.6%	3.2%	3.0%

# Хураангуй орлого үр дүнгийн тайлан

2024 оны 1-р улирал

Сая.Төг	2023 IV улирал	2024 I улирал	Өөрчлөлт (%)
Хүүгийн орлого	152,324	168,769	11%
Хүүгийн зардал	79,268	95,420	20%
<b>Хүүгийн цэвэр орлого</b>	<b>73,055</b>	<b>73,349</b>	<b>0%</b>
Эрсдэлийн сангийн зардал	-	-	-
Бусад орлого	27,506	19,907	-28%
Бусад зардал	45,930	36,168	-21%
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>54,631</b>	<b>57,088</b>	<b>4%</b>
Орлогын татварын зардал	16,552	11,096	-33%
Хойшлогдсон татварын зардал (орлого)	(2,342)	3,934	-268%
<b>Татварын дараах ашиг</b>	<b>40,422</b>	<b>42,057</b>	<b>4%</b>

## Тайлбар:

- Нийт зээл болон санхүүгийн түрээсийн багц өмнөх улирлаас 5.9% өссөн нь хүүгийн орлого 11%-р өсөхөд нөлөөлсөн байна.
- Хүүгийн зардал өсөхөд, харилцах хадгаламжид төлсөн хүү болон гадаад эх үүсвэрийн хүүгийн зардал өссөн нь голчлон нөлөөлсөн байна.
- Тайлант хугацаанд чанаргүй зээлийн төлөлт нэмэгдсэн нь эрсдэлийн сангийн зардал бусад орлого болон бусад зардал тус тус буурсан нь санхүүгийн жилийн эхний улирлын мөчлөгтэй холбоотой байна.

# Хураангуй тэнцэл

## 2024 оны 1-р улирал

Сая.Төг	2023 IV улирал	2024 I улирал	Өөрчлөлт (%)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	407,097	353,853	-13%
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	684,150	313,633	-54%
Хөрөнгө оруулалт	1,075,432	1,172,745	9%
Зээл (цэвэр дүнгээр)	2,720,351	2,887,004	6%
Зээлийн эрсдэлийн сан	(62,486)	(59,006)	-6%
Бусад хөрөнгө	232,391	218,244	-6%
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>5,119,422</b>	<b>4,945,480</b>	<b>-3%</b>
Харилцах, хадгаламж	2,876,117	2,857,690	-1%
Бусад өр төлбөр	1,621,242	1,439,989	-11%
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,497,359</b>	<b>4,297,678</b>	<b>-4%</b>
<b>НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>622,063</b>	<b>647,802</b>	<b>4%</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>5,119,422</b>	<b>4,945,480</b>	<b>-3%</b>




### Тайлбар:

- 2023 оны 4-р улиралд нөөцийн удирдлагын зорилгоор хийгдсэн богино хугацаатай актив, пассив төлөгдсөнөөр нийт актив 4.95 их наяд төгрөгт болж, өмнөх улирлаас 3% буурсан байна.
- Тайлант хугацаанд жижиг дунд бизнесийн зээл болон цахим зээл олголт нэмэгдэж, цэвэр зээлийн багц 6%-р өслөө.
- Харилцагчаас татан төвлөрүүлсэн эх үүсвэр (харилцах, хадгаламж) тогтвортой байсан болон бусад эх үүсвэр гэрээний үүргийн дагуу төлөгдөж 11%-р буурсан.

# Ногдол ашгийн талаар мэдээлэл

## 2023 оны санхүүгийн жилийн

ХасБанк нь 2023 оны 1-р хагас жилийн цэвэр ашгаас 15.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараасан бөгөөд 2023 оны 2-р хагас жилийн цэвэр ашгаас 26.6 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар санал болгож байна. Ингэснээр 2023 оны санхүүгийн жилийн цэвэр ашгийн 30%-ийг ногдол ашиг хэлбэрээр тарааж, Үнэт Цаасны танилцуулгад тусгасан зорилтыг биелүүлж байна.



\* Хаслизинг ХХК нь ХасБанк ХХК-д 2021 онд нэгдсэн бөгөөд ХасБанкны санхүүгийн тайланг бэлтгэхдээ ХасЛизинг ХХК-ийн санхүүгийн үзүүлэлтийг 2020 оноос эхлэн нөлөөлүүлж, толилуулсан болно. Энэ талаар ХасБанкны аудитлагдсан тайлангийн №11-12 хуудаснаас үзнэ үү.

